

ТОГТМОЛ ХЭВЛЭЛИЙН НИЙГЭМ-УЛС ТӨРИЙН СЭДЭВТ
МЭДЭЭНИЙ ЭХ СУРВАЛЖИЙГ СУДАЛСАН НЬ

Т.Оюунбилэг*

* "Номун далай" коллежийн захирал, МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн докторант

Түлхүүр үг: мэдээллийн эх сурвалж, нийгэм-улс төрийн сэдэвт мэдээ, мэдээллийн тэнцвэрт байдал, эх сурвалжийн ангилал.

Эх сурвалж бол аливаа нийтлэлийн амин сүнс мөн. Сонин хэвлэлийн нийтлэл болгон ямар нэг байдлаар эх сурвалжаа дурьдсан байхыг сэтгүүл зүйн онол шаарддаг.

Сэтгүүл зүй судлаач, шинжлэх ухааны доктор М.Зулькафиль эх сурвалжийн ач холбогдлын талаар: «Аливаа бүтээлийн үр өгөөж, үр ашиг, нийгэд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол нь ямар эх сурвалжаас мэдээлэл олж авсан, ямар баримтад үндэслэн бичсэнээс шууд шалтгаалдаг. /.../ Сайн нийтлэл бүтээхийн гол эх үндэс нь сэтгүүлч эх сурвалжийг зөв сонгож, маш нямбай, хариуцлагатай хандах явдал байдаг. Тиймээс дэлхий дахины ОНМХ-ийн практикт эх сурвалжийг сэтгүүл зүйн онол, практик, арга зүйн хамгийн чухал асуудал, гол категориудын нэг гэж үздэг.

Энэ бол аливаа нийтлэл, нэвтрүүлгийн хувь заяа нь ямар эх сурвалжийг сонгож авснаас, түүний үнэн бодитой, баталгаатай эсэхээс нь шууд шалтгаалдаг онцлогтой холбоотой юм»¹ гэж оновчтой тэмдэглэсэн байдаг.

Бид тогтмол хэвлэлүүд эх сурвалжаа хэр дурьдаж буйг тогтоохоор өдөр тутмын «Өдрийн сонин», «Өнөөдөр», «Зууны мэдээ», Монголын мэдээ» сонинуудын нийгэм-улс төрийн сэдэвтэй мэдээг судалгааны объект болгон сонгож авлаа. Тэгэхдээ дээр дурьдсан хэвлэлүүдийн 2006 оны 9 дүгээр сарын дугааруудыг судалгааны эргэлтэнд орууллаа. Судлагдахууны хүрээг нэмэх зорилгоор боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, ядуурал, ажилгүйдэл, хүн ам, гэмт хэрэг, шашин зэрэг нийгмийн мэдээллийг давхар түүвэрлэсэн юм. Харин өдөр тутмын хэвлэлүүдийн «Товчхон», «Ганц өгүүлбэрээр», «Өнөөдөр», «Маргааш», «Хоёр нарны хооронд», «Хэдхэн үгээр», «Шөнийн мэдээ», «Өдрийн толь» зэрэг булан,

боломтын дор нийтлэгдсэн нэгээс хоёр өгүүлбэрээс бүрдсэн, тарчиггүй, дан пид маягийн мэдээ бид судалгааныхаа объект болгохгүй болно

Эдгэр тутмын хэвлэлүүд тэргүүн нүүрэнцээ гол төлөв мэдээнүүдийг өгдөг байхад «Өдрийн сонин»-ы хувьд өөр хачдлага ажиглагдаж байна. Тус сонин нэгдүгээр нүүрэндээ ихэвчлэн нийгэм-улс төрийн сэдэвтэй, томоохон хэмжээний цаг үеийн тулгамдсан өгүүлүүдийн эхлэлийг байрлуулдаг ажээ Харин «Өнөөдөр», «Зууны мэдээ», «Монголын мэдээ» сонин уламжлалыг хадгалж, нэгдүгээр нүүрээ мэдээгээр дүүргэдэг байна. Түүнчлэн 2, 3, 5 дугаар нүүрэнд ч мэдээ нийтлэгддэг.

Бид судалгааныхаа төстэй сэдвээр 2001 Монголын Хэвлэлийн хэсэг судлаачийн хийсэн судалгаатай харьцуулах замаар сүүлийн 6 / жилийн хугацаанд тогтмол хэвлэлийн нийгэм-улс төрийн мэдээний эх сурвалжид гарсан өөрчлөлтийг харуулахыг зорьсон юм. 2001 онд сэтгүүл зүйн доктор Б.Болд-Эрдэнэ, Ч.Чойсамба, Ч.Базар, Н.Энхцэцэг нар «Өдрийн сонин», «Өнөөдөр», «Зууны мэдээ», «Монголын мэдээ» сонины 1999, 2000 оны 4, 10 дугаар сарын дугааруудад нийтлэгдсэн нийгэм-улс төрийн сэдэвтэй мэдээнүүдийн эх сурвалжийг судалж, үр дүнг нь олны хүртээл болгосон юм².

Хүснэгт №1. Өдөр тутмын хэвлэлийн нийгэм-улс төрийн сэдэвт мэдээнд эх сурвалж ашигласан нь

Сонин	Мэдээ		Үүнээс эх сурвалжаа дурьдаагүй		Үүнээс эх сурвалжаа дурьдсан	
	1999, 2000	2006	1999, 2000	2006	1999, 2000	2006
Өдрийн сонин	591	167	412	97	179	70
	100%	100%	69,7%	58,1%	30,3%	41,9%
Өнөөдөр	784	229	660	153	125	76
	100%	100%	84,1%	66,8%	15,9%	33,2%
Зууны мэдээ	707	231	592	123	115	108
	100%	100%	83,7%	53,2%	16,3%	46,8%
Монголын мэдээ	676	207	454	125	222	82
	100%	100%	67,2%	60,4%	32,8%	39,6%
Дундаж			76,2%	59,6%	23,8%	40,4%

Сүүлийн 6-7 жилийн байдлаар өдөр тутмын хэвлэл дэх нийгэм-улс төрийн сэдэвтэй мэдээнд эх сурвалжийг дурьдах явдал дунджаар 1,7 дахин нэмэгдсэн нь хүснэгтээс харагдаж байна. Тодорхой хэвлэлийн хувьд авч үзвэл «Өдрийн сонин»-д нийгэм-улс төрийн мэдээнд эх сурвалжийг заах нь 1,3 дахин, «Өнөөдөр»-т 2,1 дахин, «Зууны мэдээ»-нд 2,9 дахин, Монголын мэдээ»-нд 1,2 дахин нэмэгдсэн байна.

Хэрэв 1999, 2000 оны байдлаар эх сурвалжийг дурьдах нь 15,9-32,8 хувьтай, дунджаар 23,8 хувьтай байсан бол 2006 оны байдлаар 33,2-46,8 хувьтай, дунджаар 40,4 хувьтай байна (хүснэгт 1-ээс үзнэ үү).

Дурьдагдсан эх сурвалжийг дотор нь сонирхлын, мэргэжлийн, үр дагаварын гэж ангилсан болно. Сонирхлын эх сурвалж бол тухайн асуудал, үйл явдал, үзэгдэлд ямар нэг эрх ашиг, сонирхлын үүднээс хандаж буй хүн (гол төлөв албан тушаалтан) юм. Тухайн асуудал, үйл явдал, үзэгдэлтэй ашиг сонирхлын ямар нэг холбогдолгүй, асуудалд мэргэжил, шинжлэх ухааны үүднээс ханддаг, мэдлэг, чадвар бүхий бие даасан субъектыг мэргэжлийн эх сурвалжид хамааруулсан болно. Харин тухайн асуудал, үйл явдал, үзэгдлийн үр дагаварыг ямар нэг хэмжээгээр хүртсэн, мэдэрсэн эх сурвалжийг бид үр дагаварын гэж үзсэн юм. Үүнийг тодруулбал шинэ номоо уншигчдад өргөн барьж буй зохиолч өөрийн бүтээлийнхээ тухай ярьж буй бол

сонирхлын эх сурвалж болно. Хэрэв тэрхүү номонд утга зохиолын шүүмжлэгч хөндлөнгөөс үнэлгээ өгч буй бол мэргэжлийн эх сурвалж болно. Харин уг номыг уншсан уншигч сэтгэгдлээ илэрхийлж буй бол үр дагаварын эх сурвалж болох билээ. Үүний нэгэн адил үерт гэрээ урсгачихсан иргэн бол үр дагаварын эх сурвалж юм. Үерийн уршгийн талаар төрийн байгууллагын түшмэл, тухайлбал Онцгой байдлын ерөнхий газрын мэргэжилтэн мэдэгдэл/сэрэмжлүүлэг хийж буй бол сонирхлын эх сурвалж болно. Харин гал усны тэрхүү гамшгийн талаар байгал орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын шинжээч дүгнэлт гаргасан бол мэргэжлийн эх сурвалжид тооцогдоно.

Хүснэгт №2-оос бид нийгэм-улс төрийн сэдэвтэй мэдээний эх сурвалж хэрхэн задарч буйг сонирхож болно. Харамсалтай нь 1999-2006 оны байдлыг харьцуулан үзэхэд төдийлөн өөрчлөлт гараагүй нь ажиглагдана. Ерөнхийдөө сонирхлын ба мэргэжлийн үр дагаварын эх сурвалжийн эзлэх жин багассан, харин үр дагаварын эх сурвалжийн тоо нэмэгдсэн байна. Сонирхлын эх сурвалжийн эзлэх жин 93 хувьтай байснаа 90,1 хувь болж буурсан ч мөн л өндөр үзүүлэлт хэвээр байгаа юм. Харин ердөө 3,7-хон хувь байсан мэргэжлийн эх сурвалж 2,2 хувь болтлоо буурсан нь түгшихээр үзүүлэлт болжээ. Ашиг сонирхлын холбогдолгүй, мэргэжлийн үнэлэлт дүгнэлт өгдөг энэ төрлийн

эх сурвалжийн эзлэх жин өндөр байх тусам үнэн бодит дүр зургийг гаргахад дөхөм юм. Учир нь сонирхлын эх сурвалж зарим нэг тохиолдолд ашиг сонирхолдоо хөтлөгдөн буруу зөрүү мэдээлэл өгөх нь бий. Уул нь бидний үзэж буйгаар сонирхлын эх сурвалж—мэргэжлийн эх сурвалж—үр дагаварын эх сурвалжийн оновчтой харьцаа нь 70%—10%—20% байвал зохистой билээ.

Аливаа асуудал, үйл явдлын мөрөөр манай сэтгүүлчид юуны түрүүнд төрийн байгууллагуудын түшмэд болон төрийн бус байгууллагуудын мэргэжилт-

нүүдийг зорьдог нь бидний судалгааны дүнгээс харагдаж байна. Харин үр дагаварын эх сурвалжийн эзлэх жин 2,3 дахин нэмэгдсэн нь бидний үзэж буйгаар тохиолдлын шинжтэй байж болно. Учир нь 2006 оны 9 дүгээр сар бол хадгаламж, зээлийн хоршоонуудын хохирогчдоос жагсаал цуглаан, хэвлэлийн бага хурал хийсэн, мэдэгдэл гаргасан үе байлаа. Өдөр тутмын дөрвөн хэвлэлийн нийгэм-улс төрийн сэдэвтэй мэдээнүүдэд нийтдээ үр дагаварын 24 эх сурвалж дурьдагдсаны бараг тэн хагасаас илүү нь ХЗХ-уудын бурангуй үйл ажиллагаанаас болж хохирсон хүмүүс байсан юм.

Хүснэгт № 2. Эх сурвалжийн ангилал

Сонин	Дурьдсан					
	Сонирхлын		Мэргэжлийн		Үр дагаварын	
	1999, 2000	2006	1999, 2000	2006	1999, 2000	2006
Өдрийн сонин	179	66	-	3	-	4
	100%	90,4%	0%	4,1%	0%	5,5%
Өнөөдөр	102	74	15	2	8	5
	81,6%	91,3%	12%	2,5%	6,4%	6,2%
Зууны мэдээ	114	110	-	3	1	4
	99,1%	94,3%	0%	2,3%	0,9%	3,4%
Монголын мэдээ	203	79	6	-	13	11
	91,4%	84,4%	2,7%	0%	5,9%	15,6%
Дундаж	93%	90,1%	3,7%	2,2%	3,3%	7,7%

Мэдээллийн тэнцвэрт байдал бол сэтгүүл зүйн үйл ажиллагааны тулгуур зарчмуудын нэг юм. Хэдий чинээ олон эх сурвалжийг ашиглана, төдий чинээ үнэн бодитой мэдээллийг уншигчдад хүргэх

боломжтой нь ойлгомжтой. Зөрчилдөөн, маргаантай үйл явдал, үзэгдэл, асуудлын үнэн бодит байдал, шалтгаан, учир холбогдлыг хоёр ба түүнээс дээш тооны эх сурвалжаас лавлаж, баталгаажуу-

лахыг олон эх сурвалж ашиглах гэдэг. Олон эх сурвалжийг ашиглах нь мэдээллийн тэнцвэрт байдлыг хангахын хамгийн гол тулгуур мөн билээ. Чухамхүү олон эх сурвалж бүхий мэдээ тодорхой асуудал, үйл явдлын учир шалтгаан, мөн чанар, цар хүрээ, үр дагаварыг нээх, өөрийнхөөрөө тодорхойлох боломжийг уншигчдад олгож буй юм.

Хэрэв 1999, 2000 оны байдлаар олон эх сурвалжийг огт ашиглаагүй хэвлэл «Өдрийн сонин», «Зууны мэдээ» сонин байсан бол 2006 оны байдлаар ийм хэвлэл гараагүй нь сайшаалтай. Өөрөөр хэлбэл, өдөр тутмын хэвлэлүүд

олон эх сурвалжийг ашиглах явдалд илүүтэй ач холбогдол өгөх болжээ гэж дүгнэж болох юм.

Ерөнхий дүр төрхөөр нь авч үзвэл 1999-2006 оны өдөр тутмын хэвлэлүүдийн нийгэм-улс төрийн сэдэвтэй мэдээнд эх сурвалж ашигласан байдал 5,2 дахин нэмэгдсэн байна. Гэхдээ нэг үйл явдлын талаарх эсрэг тэсрэг эх сурвалжийг төдийлөн их ашиглахгүй байгаа дутагдал ажиглагдлаа. Тодруулбал, ижил байр суурь, ашиг сонирхол бүхий хоёр эх сурвалжийг ашиглах явдал түгээмэл байна.

Хүснэгт №3. Эх сурвалжийн тэнцвэрт байдал

Сонин	Тэнцвэрт байдал			
	Нэг эх сурвалж		Олон эх сурвалж	
	1999, 2000	2006	1999, 2000	2006
Өдрийн сонин	179	67	-	3
	100%	95,7%	0%	4,3%
Өнөөдөр	121	71	4	5
	96,8%	93,4%	3,2%	6,6%
Зууны мэдээ	115	101	-	7
	100%	93,5%	0%	6,5%
Монголын мэдээ	218	74	4	8
	98,2%	90,2%	1,8%	9,8%
Дундаж	98,7%	93,2%	1,3%	6,8%

Дурьдагдсан эх сурвалжийг бид хэлбэрийнх нь хувьд хувь хүн, байгууллага, төр засаг гэж гурав ангиллаа. Хувь хүн бол төрийн болон төрийн бус ямар нэг байгууллагыг

төлөөлөөгүй, асуудалд зөвхөн иргэний хувиар хандаж буй эх сурвалж юм. Тодорхой асуудал, үйл явдал, үзэгдлийн талаар байгууллагынхаа (улс төрийн нам, эвслүүд, түүнчлэн гол төлөв төрийн

бус болон олон улсын байгууллагууд) нэрийн өмнөөс байр суурийг нь илэрхийлж буй албан тушаалтныг байгууллага гэсэн ангилалд хамааруулж үзэв. Харин төр засаг болон түүний байгууллага, тэдгээрийг төлөөлж буй албан тушаалтныг *төр засгийн эх сурвалжид* тооцов.

Хүснэгт №4-ийг үзэхэд ерөнхийдөө сэтгүүлчид нийгэм-улс төрийн мэдээ

бэлтгэхдээ төр засгийн эх сурвалжийг тойрдог нь багасахын сацуу хувь хүн, байгууллагын эх сурвалжийн эзлэх жин нэмэгдэж байгааг төвөггүй анзаарч болно.

1999, 2000 оны өдөр тутмын хэвлэлд («Өнөөдөр» сониныг эс тооцвол) хувь хүнийг эх сурвалжийн хувьд ашиглах нь 0-3,2 хувьтай байсан нь тун ч хангалтгүй үзүүлэлт юм.

Хүснэгт №4. Эх сурвалжийн хэлбэр

Сонин	Эх сурвалжийн хэлбэр					
	Хувь хүн		Байгууллага		Төр засаг	
	1999, 2000	2006	1999, 2000	2006	1999, 2000	2006
Өдрийн сонин	-	7	46	23	133	43
	0%	9,6%	25,7%	31,5%	74,3%	58,9%
Өнөөдөр	48	13	35	31	42	37
	38,4	16,0%	28%	38,3%	33,6%	45,7%
Зууны мэдээ	2	8	42	37	71	72
	1,7%	6,8%	36,6%	31,6%	61,7%	61,6%
Монголын мэдээ	7	16	61	37	154	37
	3,2%	17,8%	27,5%	41,1%	69,3%	41,1%
Дундаж	10,8%	12,6%	29,5%	35,6%	59,7%	51,8%

Эх сурвалжийг дурьдсан байдлаар нь ангилж үзвэл «Өдрийн сонин»-ы 2006 оны 9 дүгээр сарын 25 дугаарын 24%-д нь хувь хүнийг, 60%-д нь байгууллагыг, 72%-д нь төр засгийн эх сурвалжийг ашигласан бол «Өнөөдөр»-ийн мөн үеийн 24 дугаарын 37,5%-д нь хувь хүнийг, 70,8%-д нь байгууллагыг, 79,2%-д нь төр засгийн эх сурвалжийг, «Зууны мэдээ»-гийн 25 дугаарын 20%-д нь хувь

хүнийг, 84%-д нь байгууллагыг, 92%-д нь төр засгийн эх сурвалжийг, «Монголын мэдээ»-гийн 22 дугаарын 45,5%-д нь хувь хүнийг, 83,4%-д нь байгууллагыг, 81,8%-д нь төр засгийн эх сурвалжийг ашигласан байна. Сэтгүүлчид төр засгийн байгууллагын албан тушаалтныг гол эх сурвалжаа болгодог нь эндээс харагдаж байна.

«... Хувь хүнийг эх сурвалжийн төвшинд ашигладаггүй нь эх сурвалжийн сонголт, боловсруулалтад буй ... нэгэн сөрөг тал мөн. Гэмт хэрэг, тэнэмэл хүүхдүүд, ажилгүйдэл, ядуурал гээд нийгмийн эмзэг сэдэв бүхий мэдээ, мэдээлэлд холбоотой, түүний үр дагаварыг хүртэгсдийг эх сурвалж болгон ашигладаггүй, тэрчлэн сэтгүүлч энэ чиглэлийн мэдээлэл авсан эх сурвалжаа заадаггүй хандлага...»³ одоо ч ажиглагдсаар байна.

Эх сурвалжийг ямар нэг байдлаар дурьдсан нийгэм-улс төрийн сэдэвтэй мэдээнүүдэд ажиглагдаж буй дутагдлуудад бид ихээхэн ач холбогдол өгсөн юм. Учир нь эдгээр дутагдлыг илрүүлж, мөн чанарыг нь нээснээр бид эх сурвалж ашиглалтыг илүү өндөр төвшинд гаргах боломжтой болно.

Бид нэгдүгээрт: нэр бүхий хувь хүн, мэргэжилтэн, албан тушаалтныг, хоёрдугаарт, нэр нь ямар нэг шалтгааны улмаас дурьдагдаагүй ч байгууллага, албан тушаалыг нь заасан бол дурьдагдсан эх сурвалж гэсэн ойлголтонд хамааруулж үзсэн юм. Учир нь Барууны сэтгүүл зүйн жишгээр эх сурвалжийн нэрийг дурьдах нь түүний эрхэлж буй ажил, эрүүл мэнд, цаашлаад амь насанд аюултай бол наанадаж байгууллага, албан тушаалыг нь заах хэрэгтэй билээ.

Тухайлбал: «Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрын холбогдох албан тушаалтнаас лавлахад...» (ММ, 2006.09.29.), «Энэ тухай Монголын өмгөөлөгчдийн холбооны

удирдлагаас тодруулахад...» (ММ, 2006.09.29.) зэрэг өгүүлбэрт эх сурвалжийн нэр нь байхгүй ч ядаж албан тушаал, албан газар нь дурьдагджээ. Гэхдээ эдгээр мэдээг аваад үзэхэд «Монголын мэдээ» сонины сэтгүүлчид эх сурвалжийн нэр, албан тушаалыг тодорхой заачихад болохгүй зүйл ер үгүй байсан нь ажиглагдсан юм.

Дээрхтэй ижил төстэй жишээ: «Ардчилсан намын төв байр сүүлийн үед урьд урьдынхаасаа илүү хөл ихтэй байна. Ийм байдал цаашид үргэлжилнэ гэж тус намын хэвлэл, мэдээллийн албаны төлөөлөгч амлаж байна» (ӨС, 2006.09.29.), «Энэ талаар Харилцаа холбооны зохицуулах хорооны холбогдох мэргэжилтнээс тодруулахад...» (ЗМ, 2006.09.08.)

Мөн л Ардчилсан намын хэвлэл, мэдээллийн албаны хэн гэдэг төлөөлөгч ингэж хэлснийг, телефон утас хэрэглэгчдийг ихээхэн бухимдуулаад байгаа багц үнийн талаар Харилцаа холбооны зохицуулах хорооны хэн гэдэг мэргэжилтнээс лавлагаа авсныг тодруулчихад болохгүй зүйл үгүй.

Ер нь албан газрыг нь дурьдаад холбогдох албан тушаалтнаас тодруулахад гэх маягаар бичих нь манай өдөр тутмын хэвлэлүүдийн хувьд энгийн үзэгдэл болоод байна. Албан үүргийнхээ дагуу олон нийтийн мэдэх эрхийг хүндэтгэн мэдээлэл өгч буй түшмэл хэрэв үнэн бодитой зүйл л ярьж байгаа юм бол мянга мянган уншигчдаас нэрээ нуугаад байх шаардлагагүй билээ.

Харамсалтай нь өдөр тутмын хэвлэлүүдэд нэр ч үгүй, албан тушаал ч үгүй тодорхойгүй эх сурвалж тохиолдож байна. Нэр, албан тушаал, төлөөлж буй байгууллага нь тодорхойгүй эх сурвалжийг бид дурьдагдсан эх сурвалж гэсэн ангилалд хамааруулаагүй болно. Зарим нэг жишээг үзье:

«Үндэсний эв нэгдлийн Засгийн газрын тэргүүн М.Энхболдын бие чилээрхэж тавгүйтэн уржигдар хоёрдугаар эмнэлэгт хүргэгдсэн тухай мэдээллийг зарим хэвлэл нийтэлжээ. Энэ талаар албаны эх сурвалжаас тодруулахад "Ерөнхий сайдын бие сайн байгаа. Зарим хэвлэл ташаа мэдээлжээ..." гэв». (Ө, 2006.09.13.) Энэ жишээнд албаны эх сурвалж гэж засгийн газрын ажилтныг хэлээд байна уу, аль эсвэл хоёрдугаар эмнэлгийн ажилтныг хэлээд байна уу гэдэг нь бүрхэг байна.

«Сүүлийн үед зарим хорих ангид ял эдэлж буй хоригдол амиа хорлох болон тодорхой бус шалтгаанаар нас барах тохиолдол гарах боллоо. Тиймээс бид холбогдох албаны эх сурвалжаас лавлахад...» (ММ, 2006.09.20.) гэсэн мэдээнд холбогдох албаны эх сурвалж гэж чухам хэнийг хэлээд байгаа нь (хорих ангийн ажилтан уу, эсвэл өөр

байгууллагын түшмэл үү) тодорхойгүй байна.

«САПУ-Бөмбөгөр худалдааны төвийн барилга шатаад есөн сар болж байна. Энэ хугацаанд галын шалтгааныг тогтоох шинжээчдийн баг томилогдон ажиллаж байгаа билээ. Эх сурвалжийн мэдээлж буйгаар, галын шинжээчдийн баг хоёр хуваагдаж хоёр өөр дүгнэлт гаргаад буй аж» (ЗМ, 2006.09.08.) Мөн л энэ мэдээллийг ямар

эх сурвалж сэтгүүлчид өгснийг таагаад ч хариултыг нь олоход бэрх ажээ.

«Эрэл сургуульд халдсан этгээдийг уржигдар орой барьсан гэж албаны эх сурвалж мэдээллээ. Харин өөр нэг эх сурвалж "Сэжигтнийг саатуулан шалгаж байна, гэхдээ хэрэг үйлдсэн эсэхийг яг

тогтоогоогүй байна" гэсэн юм» (ММ, 2006.09.29.) Албаны эх сурвалж гэж цагдаагийн байгууллагын ажилтныг хэлээд байна уу, хэрэв тийм бол өөр эх сурвалж ямар байгууллагын ажилтныг хэлж байна, эсвэл өөр эх сурвалж гэж мөн цагдаагийн байгууллагад ажилладаг, гэхдээ өөр албан тушаалтныг хэлж байна уу гэдгийг таах л үлджээ.

Дээрх жишээнүүдээс өдөр тутмын хэвлэлүүд ийм тодорхойгүй, бүрхэг эх сурвалжуудыг аль болох тодруулж байх

«

Эх сурвалжийг ашиглах тал дээр радио, телевиз зарчмын ялгаатай. Хэрэв тогтмол хэвлэлд эх сурвалжийг нэр ус, албан тушаалтай нь дурьдаж байж олон нийтийг итгүүлэн үнэмшүүлж чадах бол радио нь эх сурвалжийн амьд дуу хоолойг дамжуулдаг, телевиз нь дүрсийг нь гаргадаг болохоор сонсогч, үзэгчдэд сэтгэл зүйн цогц нөлөө үзүүлдэг.

»

шаардлагатай тулгараад байгаа нь харагдаж буй юм. Ер нь бүрхэг эх сурвалж «Монголын мэдээ» сонинд түлхүү тохиолдож байсныг онцлох нь зүйтэй.

«...Өнгөрөгч жил хэдэн залуу нууцаар малталт хийж асар их эд өлгийн зүйлийг ухаж гарган, хар зах дээр алт мөнгөний "Б" гэгч ченжид арилжсан тухай яриа ч байдаг гэнэ». (ММ, 2006.09.01.) Олны яриа, хов жив нь албан ёсны эх сурвалжийн мэдэгдлээр няцаагдаагүй тохиолдолд эх сурвалжийн төвшинд үнэлэгдэх нь бий. Гэвч бид дээр дурьдсан шалгуураар энэхүү мэдээнд хандаж, дурьдагдсан эх сурвалж хэмээн үзээгүй болно.

«Их, дээд сургуульд орж чадаагүй "улаан шугам"-ны цаана үлдсэн хүүхдүүд тойргоосоо сонгогдсон нутгийн ах, эрхэм төрийн түшээг "тойгдож" байгаад аль нэг нэр хүндтэй сургуулийн захирал уруу утас цохиулж автоматаар элсэхийн тулд өглөө эртлэн саарал ордны үүдийг сахидаг тухай хов чих дэлсэв. Энэ нь ч үнэний хувьтай бололтой». (ММ, 2006.09.01.) Дээрхтэй төстэй жишээ. Хамгийн гол нь сэтгүүлч өөрийнх нь чихийг дэлссэн эл ховыг баталгаатай эх сурвалжаар нотлох ёстой байсан юм. Тухайлбал, сургуулийн захирал нь байг гэхэд, сургалтын албаны дарга, эсвэл ажилтнууд, мөн захирлын тушаалтай ямар нэг байдлаар харилцдаг бичиг хэргийн болон архивын ажилтнууд энэ хов үнэн болох эсэхийг тогтооход тус

дэм болно. Ер нь өдөр тутмын хэвлэл нотлогдоогүй ховыг эх сурвалжаа болгох нь тийм ч зүйтэй үзэгдэл биш билээ.

Харин эх сурвалжийг ашиглах тал дээр радио, телевиз зарчмын ялгаатай. Хэрэв тогтмол хэвлэлд эх сурвалжийг нэр ус, албан тушаалтай нь дурьдаж байж олон нийтийг итгүүлэн үнэмшүүлж чадах бол радио нь эх сурвалжийн амьд дуу хоолойг дамжуулдаг, телевиз нь дүрсийг нь гаргадаг болохоор сонсогч, үзэгчдэд сэтгэл зүйн цогц нөлөө үзүүлдэг. Нэрээ нууцлахыг хүссэн эх сурвалжаас авсан мэдээллийг үзэхэд гээд сонинд бичихэд итгэх хүн ч бий, итгэхгүй нэгэн ч бас бий. Сэтгүүлч өөрийнхөө зохиочихсон зүйлийг нууц эх сурвалжаас авлаа гэж хаацайлдаг гэсэн ойлголттой явдаг уншигчид олон байдаг. Тэгвэл ялангуяа гэмт хэргийн тухай нэвтрүүлэгт эх сурвалжийн царайг халхлан, зөвхөн албан тушаалыг нь барагцаалан дурьдах замаар түүнийг эфирээр гаргадаг. Ингэлээ гээд үзэгчдэд үл итгэх сэтгэл төрдөггүй бөгөөд харин ч эх сурвалжид аюул учирч болзошгүй учир түүний нууц байдлыг хангаж байна гэж ойлгодог.

Ишлэл

¹ З у л ь к а ф и л ь М. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 2005, 77 дахь тал.

² Б о л д – Э р д э н э Б., Ч о й с а м б а Ч., Э н х ц э ц э г Н., Б а з а р Ч. Өдөр тутмын сонины нийгэм-улс төрийн сэдэвт мэдээний эх сурвалжийг судлах нь. УБ., 2001.

³Болд-Эрдэнэ Б., Чойсамба Ч., Энхцэцэг Н., Базар Ч. Өдөр тутмын сонины нийгэм-улс төрийн сэдэвт мэдээний эх сурвалжийг судлах нь, 3 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Андерсен Х. У., Мэллит М. Ф. нар. 1998. Нийтлэл, нэвтрүүлгийг яаж бэлтгэх вэ? (Орч. М.Зулькафиль). Хоёр дахь хэвлэл. УБ.
2. Болд-Эрдэнэ Б. 1997. Мэдээллийн эх сурвалж. «Сэтгүүлч», № 2-3.
3. Болд-Эрдэнэ Б. 2006. Олон нийтийн харилцаа. УБ.
4. Болд-Эрдэнэ Б., Чойсамба Ч., Энхцэцэг Н., Базар Ч. 2001. Өдөр тутмын сонины нийгэм-улс төрийн сэдэвт мэдээний эх сурвалжийг судлах нь. УБ.
5. Бради Р. 2005. Мэдээллийн эх сурвалжаа хамгаалах нь. УБ.

6. Зулькафиль М. 2002. Сэтгүүл зүйн онолын зарим асуудал. УБ.

7. Зулькафиль М., Чойсамба Ч. 2002. Чөлөөт хэвлэл: өчигдөр, өнөөдөр, маргааш. УБ.

8. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.

9. Менчер М. 2002. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. УБ.

10. 2002. Монгол дахь чөлөөт сэтгүүл зүйн зарим асуудал. УБ.

11. 2003. Олон нийтийн санал бодол, чөлөөт хэвлэлийн төлөвшил. Социологийн судалгааны тайлан. УБ.

12. 2006. Таны эрх зүйн хамгаалалт. Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага. УБ.

13. Merrill J. 1997. Journalism Ethics. New York, St. Martin Press.

14. 1988. News Reporting and Writing. New York.